



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 01/Н

Мандалговь

Сум, агентлагийн жилийн эцсийн хяналт
шинжилгээ, үнэлгээний бэлтгэл ажлыг хангах
ажлын хэсэг байгуулах тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/161 дүгээр тушаалаар батлагдсан “Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 21 дүгээр бүлгийн 21.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сум, агентлагийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх арга хэмжээний бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ш.Оюун (Үйлчилгээний албаны дарга)

Гишүүд:

Т.Уранбайгаль (Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Н.Мөнгөн (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн)

Б.Пүрэвжаргал (Нийгмийн бодлогын хэлтсийн
мэргэжилтэн)

Г.Мөнхбаясгалан (Санхүү төрийн сангийн хэлтсийн
мэргэжилтэн)

Хоёр. Аймгийн Засаг даргын 2019 оны А/465 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн ажилд туслах үүрэг бүхий сум, агентлагийн жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээний бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг хуралдуулж, ажил үүргийн хуваарь гаргаж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсэг (Ш.Оюун) –т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060033